ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

# 2019/10



http://www.ubstat.mn

АГУУЛГА

| | Хуудасны дугаар |
|---|---|
| ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2017-2019 ОН | 2 |
| ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ | 3 |
| НИЙГМИЙН ДААТГАЛ | 4 |
| НИЙГМИЙН ХАЛАМЖ | 6 |
| ЭРҮҮЛ МЭНД | 7 |
| АМЬДАРЧ БУЙ ОРЧИН | 8 |
| ГЭМТ ХЭРЭГ | 10 |
| ДҮҮРГИЙН ТӨСӨВ | 12 |
| ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ | 14 |
| ГАЗАР ТАРИАЛАН | 17 |
| АЖ ҮЙЛДВЭР | 18 |
| БАРИЛГА | 21 |
| МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО | 21 |
| ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ | 22 |

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний X сард

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2017 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|
| Суурин хүн ам, сарын эцэст | хүн | 162528 | 172970 | 182085 |
| Шинээр төрсөн хүүхэд | тоо | 3627 | 3863 | 3780 |
| Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст | хүн | 575 | 758 | 655 |
| үүнээс: эмэгтэй | хүн | 348 | 398 | 335 |
| Халдварт өвчнөөр өвчилсөн хүн | тоо | 2035 | 1700 | 1904 |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | тоо | 1487 | 1915 | 1839 |
| Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт | хувь | 0.4 | 1.2 | 0.4 |
| Валютын зах зээлийн ханш, сарын эцэст | 1US$ =₮ | 2456.2 | 2564.5 | 2697.8 |
| Дүүргийн төсвийн орлого | сая.төгрөг | 45819.0 | 62500.6 | 70553.3 |
| Дүүргийн төсвийн зарлага | сая.төгрөг | 38852.6 | 51134.2 | 61235.7 |

## ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2019 оны 10 дугаар сард 655 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 103 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 51.1 хувь нь эмэгтэйчүүд байна.

10-р сард орон тооны цомхотголоор 28, байгууллага татан буугдсанаас 10, өөр газраас шилжиж ирсэн 20, сургууль төгссөн 18, цэргээс халагдсан 50, мэргэжлийн ажил олдохгүй 36, цалин багатайгаас 77, бусад шалтгаанаар 138 хүн ажилгүй болжээ. Тайлант сард 87 хүн ажилд орсноос төрийн төсөвт байгууллагад 51, нөхөрлөл компанид 35, хоршоонд 1 хүн ажилд орсон байна.

Хүснэгт 2. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, жил бүрийн X сарын эцэст

| Үзүүлэлт | Ажилгүйчүүдийн тоо | | | Дунд эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2017 | 2018 | 2019 | 2017 | 2018 | 2019 |
| Нийт ажилгүйчүүд | 575 | 758 | 655 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Дээд боловсролтой | 287 | 375 | 367 | 50.0 | 49.5 | 56.0 |
| Тусгай дунд боловсролтой | 24 | 30 | 25 | 4.2 | 4.0 | 3.8 |
| Мэргэжлийн анхан шатны | 12 | 15 | 22 | 2.1 | 2.0 | 3.4 |
| Бүрэн дунд боловсролтой | 240 | 303 | 214 | 41.7 | 40.0 | 32.7 |
| Бүрэн бус дунд боловсролтой | 6 | 27 | 22 | 1.0 | 3.5 | 3.3 |
| Бага, боловсролгүй | 6 | 8 | 5 | 1.0 | 1.0 | 0.8 |

Зураг 1. Ажилгүйчүүд насны бүлгээр, 2019 X сард




Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 262 (40.0%) нь анх удаа ажил хайж байгаа бол 393 (60.0%) нь урьд ямар нэг ажил хийж байжээ.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 82 (12.5%) нь 16-24 насны, 260 (39.7%) нь 25-34 насны, 189 (28.9%) нь 35-44 насны, 124 (18.9%) нь 45-60 насны хүмүүс байна.

# НИЙГМИЙН ДААТГАЛ

2019 оны эхний 10 сард Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 3939 байгууллагын нийт 182.5 мянга гаруй хүн хамрагдаж, шимтгэл төлсөн ба тэдгээрийн 87.7 мянга (48.1%) нь ААНБ-ын, 11.8 мянга (6.5%) нь төсвийн байгууллагын, 9.1 мянга (5.0%) нь сайн дурын даатгуулагчид, 73.8 мянга (40.4%) нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

Хүснэгт 3.Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлсэн байгууллага болон даатгуулагчийн тоо

| Үзүүлэлт | 2018 I-X | 2019 I-X | Өсөлт | |
|---|---|---|---|---|
| | | | тоо | хувь |
| Нийт байгууллагын тоо | 3446 | 3939 | 493 | 114.3 |
| Аж ахуйн нэгж байгууллагын тоо | 3322 | 3809 | 487 | 114.7 |
| Төсөвт байгууллагын тоо | 124 | 130 | 6 | 104.8 |
| Нийт даатгуулагчдын тоо | 131563 | 182589 | 51026 | 138.8 |
| ААНБ-ын даатгуулагчийн тоо | 75824 | 87789 | 11965 | 115.8 |
| Төсөвт байгууллагын даатгуулагчийн тоо | 11310 | 11801 | 491 | 104.3 |
| Сайн дурын даатгуулагчийн тоо | 9211 | 9174 | -37 | 99.6 |
| Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо | 35218 | 73825 | 38607 | 209.6 |

2019 оны эхний 10 сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 201.7 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 18.2 тэрбум төгрөгөөр (9.9%) давж биелсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.2 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, сан тус бүрээр, 2019 оны эхний 10 сард

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | | Гүйцэтгэл | | Биелэлт % | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2018 I-X | 2019 I-X | 2018 I-X | 2019 I-X | 2018 | 2019 |
| Тэтгэврийн даатгалын сангийн орлого | 81928.8 | 121830.2 | 95576.1 | 129777.6 | 116.7 | 106.5 |
| Тэтгэмжийн сангийн орлого | 9211.6 | 12659.9 | 12298.7 | 16706.7 | 133.5 | 132.0 |
| ҮОМШӨ*-ний даатгалын орлого | 8199.8 | 10100.9 | 11529.7 | 15632.4 | 140.6 | 154.8 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого | 1898.2 | 2713.0 | 2525.3 | 3434.8 | 133.0 | 126.6 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого | 26695.6 | 36150.6 | 26695.6 | 36150.6 | 100.0 | 100.0 |
| Нийт | 127934.0 | 183454.6 | 148625.4 | 201702.1 | 116.2 | 109.9 |

Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 64.3 хувийг тэтгэврийн даатгалын санд, 8.3 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 7.8 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 1.7 хувийг ажилгүйдлийн даатгалын санд, 17.9 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

Зураг 2. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, хувиар




Зураг 3. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 15107 хүнд 64.7 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3158 хүнд 9.0 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 782 хүнд 2.5 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1172 хүнд 7.5 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 11822 хүнд 1.7 тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 4436 хүнд 7.1 тэрбум төгрөгийг, 73 хүнд оршуулгын тэтгэмж 73 сая төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 158 хүнд 807.6 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 16 хүнд 87.7 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 86 хүнд 75.3 сая төгрөгийг, ҮОМШӨ-ний сувиллын зардал 24 хүнд 3.9 сая төгрөгийг тус тус олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 1730 хүнд 3.7 тэрбум төгрөг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 68.1 хувийг тэтгэврийн, 6.8 хувийг тэтгэмжийн, 7.1 хувийг ҮОМШӨ-ний, 1.9 хувийг ажилгүйдлийн, 16.1 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал тус тус эзэлж байна.

Зураг 4. Даатгалын сангийн орлого, зарлага сая,төг




Зураг 5. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо



## НИЙГМИЙН ХАЛАМЖ

2019 оны эхний 10 сард нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 6.7 хувь нь насны хишиг тэтгэмжид, 24.3 хувь нь цалинтай ээж хөтөлбөр, 5.8 хувь нь алдарт эхийн одонгийн тусламжид тус тус хуваарилсан байна.

Харин зарлагын 50.4 хувь нь нийгмийн халамжийн санд буюу нийт 22762 хүнд, 7576 хүнд насны хишиг, 8354 хүнд алдарт эхийн одонгийн тусламж, 385 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 17189 хүнд эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, 2019 оны эхний 10 сард, сая.төг

| Үзүүлэлт | Дүн | Хүний тоо |
|---|---|---|
| Нийгмийн халамжийн сангийн орлого | 17 988.9 | |
| А. Улсын төсвийн санхүүжилтийн орлого | 17 958.1 | |
| 1) Нийгмийн халамжийн сан | 9 164.1 | |
| 2) жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж | 638.6 | |
| 3) хүнс тэжээл хөтөлбөр | 761.3 | |
| 4) алдарт эхийн одонгийн тусламж | 1 038.8 | |
| 5) алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | 543.0 | |
| 6) насны хишиг | 1 213.0 | |
| 7) цалинтай ээж хөтөлбөр | 4 374.3 | |
| 8) өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж | 225.0 | |
| Б. Хүүгийн болон бусад орлого | 30.8 | |
| а) хүүгийн орлого | 30.8 | |
| б) бусад орлого | - | |
| Зарлагын нийт дүн | 17 686.9 | 57 493 |
| 1. Нийгмийн халамжийн сан | 8 920.0 | 22 762 |
| 2. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж | 5 224.2 | 17 189 |
| 3. Алдарт эхийн одонгийн тусламж | 1 055.0 | 8 354 |
| 4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | 528.8 | 385 |
| 5. Хүнс тэжээлийн тусламж, дэмжлэг | 760.8 | 1 227 |
| 6. Насны хишиг | 1198.1 | 7 576 |

# ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2019 оны эхний 10 сард 1904 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 204 хүнээр (12.0%), 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 5.9 продицмилээр нэмэгдсэн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 30.0 хувийг салхин цэцэг, 9.2 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 4.6 хувийг тэмбүү, 5.5 хувийг гар хөл амны өвчин, 2.2 хувийг трихомониаз, 25.4 хувийг цусан суулга, 1.8 хувийг заг хүйтэн, 0.9 хувийг вируст хепатит, 20.4 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

Хүснэгт 6. Дүүрэгт гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний 10 сард

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2018 I-X | 2019 I-X | Өсөлт, бууралт 2019/2018 | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тоо/пункт | Хувь |
| НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН | Бодит тоо | 1700 | 1904 | 204 | 12.0 |
| | 10000 хүнд | 103.3 | 109.2 | 5.9 | |
| Вируст хепатит | Бодит тоо | 24 | 17 | -7 | -29.2 |
| | 10000 хүнд | 1.5 | 1.0 | -0.5 | |
| Цусан суулга | Бодит тоо | 479 | 483 | 4 | 0.8 |
| | 10000 хүнд | 29.1 | 27.7 | -1.4 | |
| Улаан эсэргэнэ | Бодит тоо | 83 | 74 | -9 | -10.8 |
| | 10000 хүнд | 5.0 | 4.2 | -0.8 | |
| Сальмонеллёз | Бодит тоо | 30 | 31 | 1 | 3.3 |
| | 10000 хүнд | 1.8 | 1.8 | 0.0 | |
| Салхин цэцэг | Бодит тоо | 472 | 571 | 99 | 21.0 |
| | 10000 хүнд | 28.7 | 32.8 | 4.1 | |
| Гахайн хавдар | Бодит тоо | 23 | 5 | -18 | -78.3 |
| | 10000 хүнд | 1.4 | 0.3 | -1.1 | |
| Ёлом | Бодит тоо | 9 | 14 | 5 | 55.5 |
| | 10000 хүнд | 0.5 | 0.8 | 0.3 | |
| Гар хөл, амны өвчин | Бодит тоо | 174 | 104 | -70 | -40.2 |
| | 10000 хүнд | 10.6 | 6.0 | -4.6 | |
| Тэмбүү | Бодит тоо | 74 | 87 | 13 | 17.6 |
| | 10000 хүнд | 4.5 | 5.0 | 0.5 | |
| Заг хүйтэн | Бодит тоо | 34 | 34 | 0 | 0 |
| | 10000 хүнд | 2.1 | 2.1 | 0.0 | |
| Трихомониаз | Бодит тоо | 47 | 42 | -5 | -10.6 |
| | 10000 хүнд | 2.9 | 2.4 | -0.5 | |
| Шинээр илэрсэн сүрьеэ | Бодит тоо | 195 | 175 | -20.0 | -10.3 |
| | 10000 хүнд | 11.8 | 10.0 | -1.8 | |
| Мөөгөнцөр | Бодит тоо | 2 | - | - | - |
| | 10000 хүнд | 0.1 | - | - | |
| Улаан бурхан | Бодит тоо | - | - | - | - |
| | 10000 хүнд | - | - | - | |
| Бусад өвчлөл | Бодит тоо | 54 | 267 | 213 | 4.9 дах |
| | 10000 хүнд | 3.3 | 15.3 | 12.0 | |

Зураг 6. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд




Зураг 7. Халдварт өвчнөөр өвчлөгчид




2019 оны эхний 10 сард нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үеэс 16 хүүхдээр, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өмнөх оны мөн үеэс 7 хүүхдээр буурсан байна.

Хүснэгт 7. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний 10 сард

| Үзүүлэлт | 2017 I-X | 2018 I-X | 2019 I-X | 2019/2018 % |
|---|---|---|---|---|
| Амаржсан эхийн тоо | 3604 | 3939 | 3744 | -4.9 |
| Амьд төрсөн хүүхэд | 3627 | 3863 | 3780 | -2.1 |
| Төрөхийн улмаас эндсэн эх | 1 | - | - | - |
| Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд | 43 | 43 | 27 | -37.2 |
| 1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд | 7 | 12 | 5 | -58.3 |

*Мэдээллийн эх сурвалж: Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв

## АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2019 оны 10 дугаар сард дунджаар 0.9$^0$C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.9$^0$C-аар сэрүүн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 16.6$^0$C, хамгийн хүйтэн хэм -11.8$^0$C, хур тунадасны нийлбэр 2.6 мм, салхины үнэмлэхүй их хурд 17 метр секунд хүрч, шороон болон цасан шуургатай өдөр бүртгэгдээгүй байна.

Хүснэгт 8. Агаарын бохирдолт, мг/м$^3$, X сард[1]

| Бодисын нэр | | Стандарт хэмжээ | Хэмжил-тийн тоо | Хамгийн их хэмжээ | Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо | Агаарт байсан дундаж хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|
| Хүхэрлэг хий | $SO_2$ | 0.050 | 318 | 0.184 | 50 | 0.026 |
| Азотын давхар исэл | $NO_2$ | 0.050 | 247 | 0.109 | 82 | 0.041 |
| Тоосжилт | $PM_{10}$ | 0.100 | 337 | 0.351 | 178 | 0.118 |
| | $PM_{2.5}$ | 0.050 | 212 | 0.106 | 48 | 0.039 |
| Нүүрстөрөгчийн дутуу исэл[2] | CO | 10.000 | 360 | 7.785 | - | 1.093 |
| Озон | $O_3$ | 0.100 | 551 | 0.095 | - | 0.021 |

[1] Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар
[2] 8 цагийн дундаж

Хүснэгт 9. Хан-Уул дүүргийн агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м$^3$, X сард

| Агаарын бохирдлын үзүүлэлт | | Мишээл-Экспо төв | | | Нисэх | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2017 | 2018 | 2019 | 2017 | 2018 | 2019 |
| | | Мг/м$^3$ | | | | | |
| Хүхэрлэг хий $SO_2$ | Дундаж | 0.024 | | 0.012 | 0.004 | 0.003 | - |
| | Хамгийн их | 0.053 | | 0.038 | 0.009 | 0.007 | - |
| | ХХХ*-с давсан хувь | 4.0 | | - | - | - | - |
| | Хэмжилтийн тоо | 25 | | 31 | 26 | 31 | - |
| Азотын давхар исэл $NO_2$ | Дундаж | - | | - | 0.012 | 0.012 | 0.017 |
| | Хамгийн их | - | | - | 0.029 | 0.022 | 0.033 |
| | ХХХ*-с давсан хувь | - | | - | - | - | - |
| | Хэмжилтийн тоо | - | | - | 28 | 31 | 25 |
| Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO** | Дундаж | - | | - | 0.599 | - | - |
| | Хамгийн их | - | | - | 1.273 | - | - |
| | ХХХ*-с давсан хувь | - | Хэмжилт хийгдээгүй | - | - | - | - |
| | Хэмжилтийн тоо | - | | - | 83 | - | - |
| Тоос $PM_{10}$ | Дундаж | 0.084 | | 0.106 | 0.123 | 0.127 | 0.162 |
| | Хамгийн их | 0.140 | | 0.200 | 0.254 | 0.241 | 0.342 |
| | ХХХ*-с давсан хувь | 39.0 | | 58.0 | 64.0 | 68.0 | 77.0 |
| | Хэмжилтийн тоо | 18 | | 31 | 28 | 31 | 31 |
| Тоос $PM_{2.5}$ | Дундаж | - | | - | 0.057 | 0.044 | 0.042 |
| | Хамгийн их | - | | - | 0.096 | 0.071 | 0.083 |
| | ХХХ*-с давсан хувь | - | | - | 61.0 | 42.0 | 32.0 |
| | Хэмжилтийн тоо | - | | - | 28 | 31 | 28 |
| Озон O3** | Дундаж | 0.021 | | 0.013 | 0.017 | 0.021 | 0.035 |
| | Хамгийн их | 0.037 | | 0.039 | 0.034 | 0.037 | 0.095 |
| | ХХХ*-с давсан хувь | - | | - | - | - | - |
| | Хэмжилтийн тоо | 43 | | 93 | 83 | 93 | 87 |

* Хүлцэх хэм хэмжээ, **CO, O3 -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2019 оны 10-р сарын танилцуулга

## Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2019 оны 10 дугаар сарын 9, 10-ны өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд амоны азот 4.2 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 3.2 дахин, эрдэс фосфор 1.2 дахин хүлцэх хэмжээнээс давж, Туул голын ус бохирдолтой байна.

Хүснэгт 10. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м$^3$, X сард

| Үзүүлэлт | | Стандарт хэмжээ | “Туул-Налайх” харуул цэг | | “Туул-Сонгино доод” харуул цэг | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэмжээ | Бодисын хэтрэлт | Хэмжээ | Бодисын хэтрэлт |
| Хүчилтөрөгч | $O_2$ | ≥6 | 9.78 | Хэвийн | 7.85 | 1.3 дахин |
| Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч | $БХХ_5$ | ≤ 3 | 0.6 | Хэвийн | 9.7 | 3.2 дахин |
| Нитритийн нэгдэл | $NO_2$ | ≤ 0.02 | 0.002 | Хэвийн | 0.084 | 4.2 дахин |
| Амоны азот | $NH_4$ | ≤0.5 | 0.03 | Хэвийн | 2.12 | 4.2 дахин |
| Эрдэс фосфор | P | ≤0.1 | 0.003 | Хэвийн | 0.12 | 1.2 дахин |

# ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд 2019 оны эхний 10 сард 1839 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 76 (4.0%) хэргээр буурсан байна.

Зураг 8. Гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 10 сард




Нийт гэмт хэргийн 516 (28.1%) нь хулгайн хэрэг, 389 (21.1%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 418 (22.7%) хэрэг нь залилан мэхлэх гэмт хэрэг, 24 (1.3%) нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг, 16 (0.9%) нь хүчингийн хэрэг, 37 (2.0%) нь дээрэмдэх хэрэг, 72 (3.9%) нь ХАБТХАЖЭ хэрэг, 14 (0.8%) нь хүнийг алах хэрэг, 13 (0.7%) нь малын хулгайн хэрэг, 1 (0.1%) олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах, 339 (18.4%) нь бусад гэмт хэргүүд тус тус ээлж байна.

Хүснэгт 11. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 10 сард

| Гэмт хэргийн төрөл | Гэмт хэргийн тоо | | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|
| | 2018 I-X | 2019 I-X | $\frac{2018}{2019}\%$ | Тоо |
| Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | 22 | 24 | 9.1 | 2 |
| Хүчин | 14 | 16 | 14.3 | 2 |
| Дээрэмдэх | 53 | 37 | -30.2 | -16 |
| Хулгай | 615 | 516 | -16.1 | -99 |
| Залилан мэхлэх | 321 | 418 | 30.2 | 97 |
| Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 513 | 389 | -24.2 | -124 |
| Малын хулгай | 13 | 13 | 0.0 | 0 |
| Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах | 3 | 1 | -66.7 | -2 |
| Хүнийг санаатай алах | 5 | 14 | 180.0 | 9 |
| ХАБТХАЖЭ | 68 | 72 | 5.9 | 4 |
| Бусад | 288 | 339 | 17.7 | 51 |
| Бүгд | 1915 | 1839 | -4.0 | -76 |

*ХАБТХАЖЭ-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Нийт хулгайн хэрэг 516 байгаагаас 85.5 хувь нь иргэний өмчийн хулгай, 4.8 хувь нь халаасны хулгай, 1.2 хувь нь авто тээврийн хэрэгслийн хулгайн хэрэг ээлж байна.

Хүснэгт 12. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор

| Хороо | Гэмт хэрэг | | Өөрчлөлт | | Хүнийг алах | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | Үүнээс | Хүчин | Хулгай | Үүнээс | | | Дээрэмдэх | Залилан мэхлэх | Малын хулгай | Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах | ХАБТХАЖЭ | Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2018 I-IX | 2019 I-IX | Тоо | % | | | | Гэр бүлийн хүчирхийлэл | | | ИӨХ | Авто тээврийн хэрэгсэл хулгайлах | Халаасны хулгай | | | | | | |
| 1 | 94 | 91 | -3 | -3.2 | 0 | 0 | 11 | 0 | 0 | 25 | 16 | 1 | 4 | 6 | 22 | 0 | 0 | 3 | 24 |
| 2 | 170 | 147 | -23 | -13.5 | 1 | 5 | 24 | 0 | 1 | 24 | 16 | 0 | 4 | 9 | 44 | 0 | 0 | 8 | 31 |
| 3 | 246 | 214 | -32 | -13.0 | 0 | 3 | 41 | 0 | 1 | 51 | 36 | 0 | 6 | 4 | 56 | 0 | 0 | 6 | 52 |
| 4 | 171 | 156 | -15 | -8.8 | 1 | 4 | 43 | 0 | 0 | 40 | 36 | 2 | 2 | 3 | 31 | 0 | 0 | 9 | 25 |
| 5 | 56 | 38 | -18 | -32.1 | 0 | 1 | 11 | 0 | 0 | 11 | 11 | 0 | 0 | 1 | 3 | 0 | 0 | 3 | 8 |
| 6 | 47 | 41 | -6 | -12.8 | 1 | 2 | 15 | 0 | 1 | 15 | 15 | 0 | 0 | 0 | 4 | 0 | 0 | 1 | 2 |
| 7 | 35 | 38 | 3 | 8.6 | 1 | 0 | 13 | 0 | 1 | 15 | 13 | 0 | 2 | 1 | 6 | 0 | 0 | 1 | 0 |
| 8 | 76 | 61 | -15 | -19.7 | 1 | 1 | 15 | 1 | 2 | 15 | 15 | 0 | 0 | 2 | 17 | 2 | 0 | 1 | 5 |
| 9 | 65 | 46 | -19 | -29.2 | 3 | 0 | 15 | 0 | 1 | 15 | 15 | 0 | 0 | 0 | 6 | 0 | 0 | 1 | 5 |
| 10 | 179 | 132 | -47 | -26.3 | 1 | 1 | 36 | 0 | 2 | 39 | 38 | 1 | 0 | 2 | 21 | 0 | 0 | 9 | 21 |
| 11 | 241 | 282 | 41 | 17.0 | 2 | 3 | 43 | 2 | 0 | 83 | 69 | 0 | 3 | 3 | 78 | 0 | 0 | 7 | 63 |
| 12 | 62 | 63 | 1 | 1.6 | 2 | 0 | 17 | 0 | 3 | 24 | 23 | 1 | 0 | 0 | 2 | 5 | 0 | 4 | 6 |
| 13 | 50 | 50 | 0 | 0.0 | 0 | 0 | 17 | 0 | 1 | 18 | 18 | 0 | 0 | 0 | 3 | 3 | 0 | 2 | 6 |
| 14 | 79 | 73 | -6 | -7.6 | 0 | 0 | 16 | 0 | 2 | 37 | 37 | 0 | 0 | 1 | 2 | 3 | 0 | 8 | 4 |
| 15 | 262 | 336 | 74 | 28.2 | 0 | 1 | 60 | 0 | 1 | 80 | 59 | 1 | 4 | 3 | 112 | 0 | 1 | 5 | 73 |
| 16 | 82 | 71 | -11 | -13.4 | 1 | 3 | 12 | 1 | 0 | 24 | 24 | 0 | 0 | 2 | 11 | 0 | 0 | 4 | 14 |
| Дүн | 1915 | 1839 | -76 | -4.0 | 14 | 24 | 389 | 4 | 16 | 516 | 441 | 6 | 25 | 37 | 418 | 13 | 1 | 72 | 339 |

*ХАБТХАЖЭ-хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Зураг 9. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор



## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2019 оны эхний 10 сард 70.5 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 1.4 тэрбум төгрөгөөр (2.1%) илүү бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2018 оноос 12.9 хувь өссөн байна. Төсвийн нийт орлогын 37.8 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 7.2 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого), 55.0 хувийг улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна.

Зураг 10. Төсвийн орлого, зарлага, 2012-2019 оны эхний 10 сард, сая төг




Татварын орлогын хэмжээ 26.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 914.3 сая төгрөгөөр буюу (3.3%) дутуу бүрдсэн байна. Татварын бус орлого 5.0 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 2.4 тэрбум төгрөгөөр буюу (90.0%) давж биелсэн байна.

Хүснэгт 13. Дүүргийн төсвийн орлого, 2019 оны эхний 10 сард, сая.төг

| | Төсвийн орлого | | | Үүнээс: | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Татварын орлого | | | Татварын бус орлого | | | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн орлого | | |
| | Бүгд | ТБ % | Зөрүү сая. төг | Бүгд | ТБ % | Зөрүү сая.т | Бүгд | ТБ % | Зөрүү сая.т | Бүгд | ТБ % | Зөрүү сая.т |
| Дүн | 70553.3 | 102.1 | 1432.5 | 26698.7 | 96.7 | -914.3 | 5089.7 | 190.0 | 2411.5 | 38764.9 | 99.8 | -64.6 |

Орлогын албан татвар төлөвлөснөөс 322.7 сая төгрөгөөр, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 21.9 сая төгрөгөөр, бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 569.8 сая төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

Зураг 11. Татварын орлогын бүтэц, хувиар




Зураг 12. Татварын бус орлогын бүтэц, хувиар



Хүснэгт 14. Дүүргийн төсвийн орлого, 2019 оны эхний 10 сард, сая.төг

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | ТБ хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|
| Орон нутгийн орлого | 69120.8 | 70553.3 | 102.1 | 1432.5 |
| 1.Татварын орлогын дүн | 27613.1 | 26698.7 | 96.7 | -914.3 |
| 1.1 Орлогын албан татвар | 21280.4 | 20957.7 | 98.5 | -322.7 |
| Хувь хүний орлогын албан татвар | 21280.4 | 20957.7 | 98.5 | -322.7 |
| 1.2 Хөрөнгийн албан татвар | 67.4 | 45.5 | 67.5 | -21.9 |
| 1.3 Бусад татвар,төлбөр, хураамж | 6265.3 | 5695.5 | 90.9 | -569.8 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 4720.0 | 4654.8 | 98.6 | -65.2 |
| Ашигт малтмал ашигласны төлбөр | 75.3 | 52.1 | 69.2 | -23.2 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 1470.0 | 975.9 | 66.4 | -494.1 |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр | 0.0 | 12.7 | 0.0 | 12.7 |
| 2.Татварын бус орлогын дүн | 2678.2 | 5089.7 | 190.0 | 2411.5 |
| Хүүгийн орлого | 0.0 | 2937.1 | 0.0 | 2937.1 |
| Торгуулийн орлого | 1947.5 | 1324.7 | 68.0 | -622.8 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого* | 697.1 | 793.7 | 113.8 | 96.6 |
| Бусад орлого | 33.6 | 34.2 | 101.8 | 0.6 |
| 3. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 38829.5 | 38764.9 | 99.8 | -64.6 |
| Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 38338.2 | 38303.9 | 99.9 | -34.3 |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 491.3 | 461.0 | 93.8 | -30.3 |

*Төсөвт байгууллагын өөрийн орлого нь үндсэн болон туслах орлогын нийлбэр дүн

2019 оны эхний 10 сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 61.2 тэрбум төгрөгийн (88.6%) зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 7.9 тэрбум төгрөгийг (11.4%) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Төсвийн нийт зарлагын 41.1 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 5.1 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 19.3 хувийг татаас болон урсгал шилжүүлэг, 34.5 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 15. Дүүргийн төсвийн орлого, зарлага, 2019 оны эхний 10 сард сая.төг

| | Орлого | Зарлага | | | | Орлого, зарлагын зөрүү |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү | |
| Нийт дүн | 70553.3 | 69142.7 | 61235.7 | 88.6 | -7907.0 | 9317.6 |

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд 474.1 сая төгрөгийн өглөгтэй байсан бөгөөд 126.9 сая төгрөгийн өглөг шинээр үүсч, 111.1 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, сарын эцэст нийт 489.9 сая төгрөгийн өглөгтэй болсон байна.

Хүснэгт 16. Өглөг, 2019 оны эхний 10 сард, сая.төг

| | 10-р сарын эхний үлдэгдэл | Шинээр үүссэн өглөг | Тухайн сард төлөгдсөн | 10-р сарын эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| Нийт дүн | 474.1 | 126.9 | 111.1 | 489.9 |

## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2019 оны 10 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2018 оны эцэстэй харьцуулахад 5.4 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.5 хувиар тус тус өсөж, 9 дүгээр сартай харьцуулахад 0.6 хувиар буурсан байна.

Зураг 13. Хэрэглээний үнийн индекс




Хэрэглээний үнийн индекс 2019 оны 10 дугаар сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 5.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 11.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 2.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 7.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 1.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 2.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.7 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 15.6 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 7.0 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 9.5 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 4.4 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 17. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

| Бараа, үйлчилгээний бүлгийн нэр | 2018-X / 2017-X | 2019-X / 2018-X | 2019-X / 2018-XII | 2019-X / 2019-IX |
|---|---|---|---|---|
| **Ерөнхий индекс** | **106.8** | **108.5** | **105.4** | **99.4** |
| Хүнсний бараа, ундаа, ус | 104.9 | 115.9 | 111.7 | 98.0 |
| Согтууруулах ундаа, тамхи | 108.8 | 102.8 | 102.4 | 100.1 |
| Хувцас, бөс бараа, гутал | 101.8 | 111.6 | 107.3 | 100.6 |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 116.7 | 108.6 | 101.1 | 100.0 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 105.7 | 104.4 | 102.5 | 100.3 |
| Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ | 116.0 | 104.9 | 102.7 | 100.2 |
| Тээвэр | 107.4 | 97.7 | 96.7 | 99.3 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 98.5 | 100.2 | 100.2 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 113.0 | 117.9 | 115.6 | 98.0 |
| Боловсролын үйлчилгээ | 106.8 | 107.0 | 107.0 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр | 103.5 | 112.2 | 109.5 | 100.0 |
| Бусад бараа, үйлчилгээ | 104.6 | 106.5 | 104.4 | 100.4 |

2019 оны 10 дугаар сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 23.3 хувийнх нь үнэ өсөж, 6.1 хувийнх нь үнэ буурч, 70.6 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.

Хүснэгт 18. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекс, /зөрэг, сөрөг/

| Бараа, үйлчилгээний бүлэг | Үнийн өөрчлөлт % | Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт |
|---|---|---|
| Хүнсний бараа, ундаа, ус | 2.0 | Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн бууралт нь мах, махан бүтээгдэхүүний бүлгийн үнэ 3.8 хувиар, хүнсний ногооны бүлгийн үнэ 12.2 хувиар тус тус буурсантай холбоотой байв. |
| Согтууруулах ундаа, тамхи | 0.1 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд шар айрагны үнэ 1.2 хувиар өссөн нь шууд нөлөөлсөн байна. |
| Хувцас, бөс бараа, гутал | 0.6 | Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөд хөвөн, бөс барааны бүлгийн үнэ 0.5 хувиар, бүх төрлийн хувцасны бүлгийн үнэ 0.1 хувиар, жижиг эдлэл, хэрэгслийн бүлгийн үнэ 2.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв. |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 0.3 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд гэр ахуйн оёмол, нэхмэл эдлэлийн бүлгийн үнэ 1.0 хувиар, гэр ахуйн шилэн эдлэл, сав суулганы бүлгийн үнэ 0.1 хувиар, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. |
| Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ | 0.2 | Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөд эм, тарианы бүлгийн үнэ 0.2 хувиар, эмнэлгийн туслах үйлчилгээний бүлгийн үнэ 0.1 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. |
| Тээвэр | 0.7 | Энэ бүлгийн үнийн бууралтад агаарын зорчигч тээврийн үйлчилгээний үнэ 13.0 хувиар буурсан нь шууд нөлөөлөв. |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 2.0 | Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнийн бууралтад амралт, аялал, жуулчлалын үйлчилгээний үнэ 5.8 хувиар буурсан нь нөлөөлсөн байна. |
| Бусад бараа, үйлчилгээ | 0.4 | Бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөд гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлсийн үнэ 0.6 хувиар, хувь хүний бусад эд зүйлсийн үнэ 0.2 хувиар өссөн нь нөлөөлөв. |

2019 оны 10-р сарын 25-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад задгай сүүний үнэ 200 төгрөгөөр буурч, “Талх чихэр” ХК-ны “Атар” талх 90 төгрөг, хонины мах 1100 төгрөг, үхрийн мах 1700 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 50 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 130 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурил 40 төгрөг, элсэн чихэр 500 төгрөг, байцай 650 төгрөг, манжин 750 төгрөг, сонгино 650 төгрөг, цагаан будаа 250 төгрөг, фужи алим 600 төгрөгөөр тус тус өссөн байна. Харин төмс, лууван, “Сүү” ХК-ны цөцгийтэй тарагны үнэ тогтвортой байлаа.

Хүснэгт 19. Хүнсний өргөн хэрэглээний барааны дундаж үнэ*, төгрөг, жил бүрийн X сард

| Бүтээгдэхүүний нэр | Хэмжих нэгж | 2018 | 2019 | $\frac{2019}{2018}\%$ |
|---|---|---|---|---|
| Талх “Атар”, “Талх чихэр” ХК | Ширхэг | 1160 | 1250 | 107.8 |
| Хонины мах, ястай | Кг | 5200 | 6300 | 121.2 |
| Үхрийн мах, ястай | Кг | 7300 | 9000 | 123.3 |
| Гурил , дээд зэрэг, “Алтан тариа” ХК, | Кг | 1450 | 1500 | 103.4 |
| Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа” ХК, | Кг | 1120 | 1250 | 111.6 |
| Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа” ХК, | Кг | 900 | 940 | 104.4 |
| Элсэн чихэр | Кг | 2200 | 2700 | 122.7 |
| Төмс, монгол | Кг | 800 | 800 | 100.0 |
| Байцай, монгол | Кг | 650 | 1300 | 200.0 |
| Лууван, монгол | Кг | 1300 | 1300 | 100.0 |
| Манжин, монгол | Кг | 1200 | 1950 | 162.5 |
| Сонгино, хятад | Кг | 1300 | 1950 | 150.0 |
| Цагаан будаа | Кг | 3000 | 3250 | 108.3 |
| Алим, фужи | Кг | 4300 | 4900 | 114.0 |
| Сүү, задгай | литр | 1600 | 1400 | 87.5 |
| Тараг, цөцгийтэй, “Сүү ” ХК | литр | 2530 | 2530 | 100.0 |

*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсуврага” төв

Зураг 14. Нэг кг махны дундаж үнэ, төгрөг




Зураг 15. Нэг кг гурилын дундаж үнэ, төгрөг




Зураг 16. Нэг кг төмс, лууван, байцайны дундаж үнэ, төгрөг




Зураг 17. Нэг кг манжин, сонгины дундаж үнэ, төгрөг



Хүснэгт 20. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

| ШТС | 2018.X.27 | | | | | 2019.X.25 | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Аи 95 | Аи 80 | Аи 92 | Дизель түлш | Газ | Аи 95 | Аи 80 | Аи 92 | Дизель түлш | Газ |
| Жаст Ойл | | 1 780 | 1 950 | 2 220 | | | 1 600 | 1 780 | 2 300 | |
| Петровис | 2 345 | 1 845 | 1 985 | 2 385 | | 2 240 | 1 750 | 1 840 | 2 370 | |
| Магнай трейд | 2 340 | | 1 980 | 2 380 | | 2 240 | | 1 840 | 2 370 | |
| Сод монгол | 2 300 | | 1 980 | 2 380 | | 2 240 | | 1 840 | 2 360 | |
| Шунхлай | 2 320 | 1850 | 1 985 | 2 385 | | 2 240 | | 1 840 | 2 370 | |
| Юнигаз | | | | | 1 300 | | | | | 1 300 |
| Дундаж үнэ | 2 326 | 1 825 | 1 976 | 2 350 | 1 300 | 2 240 | 1 675 | 1 828 | 2 354 | 1 300 |

*Мэдээллийн эх сурвалж: Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний үнийн 10-р сарын мэдээ

## ГАЗАР ТАРИАЛАН

*Ургац хураалт:* 2019 оны эхний 10 сард дүүргийн хэмжээнд 253.5 тонн төмс, 2946.4 тонн хүнсний ногоо хураан авсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төмс 33.6 хувиар, хүнсний ногоо 0.6 хувиар доогуур байна.

Хүснэгт 21. Хураасан ургац, нэр төрлөөр, X сард

| | 2018-X | 2019-X | Өсөлт бууралт /хувиар/ |
|---|---|---|---|
| Төмс | 382.0 | 253.5 | -33.6 |
| Хүнсний ногоо | 2963.7 | 2946.4 | -0.6 |
| Байцаа | 2475.4 | 2557.1 | 3.3 |
| Лууван | 64.7 | 35.3 | -45.4 |
| Шар манжин | 41.8 | 45.0 | 7.4 |
| Улаан манжин | 21.1 | 11.5 | -45.5 |
| Сонгино | 23.1 | 13.3 | -42.4 |
| Сармис | 4.2 | 2.0 | -52.4 |
| Өргөст хэмх | 127.4 | 199.2 | 56.4 |
| Улаан лооль | 58.6 | 33.2 | -43.3 |
| Тарвас | 16.5 | 0 | -100.0 |
| Амтат гуа | 3.8 | 0.03 | -99.2 |
| Хулуу | 7.0 | 0.2 | -97.1 |
| Чинжүү | 14.6 | 19.4 | 32.9 |
| Бусад | 104.7 | 30.2 | -71.2 |

Зураг 18. Хураасан ургац, X сард



## АЖ ҮЙЛДВЭР

Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2019 оны эхний 10 сард 1032.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1084.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 12.5 хувиар, борлуулалт 26.8 хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 838.9 тэрбум төгрөгийг дотоодод, 245.8 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 22.7 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 97.0 хувийг ноос, ноолуур, нэхмэлийн үйлдвэрлэлт, 1.0 хувийг арьс ширний үйлдвэрлэлт, 0.4 хувийг ундаа үйлдвэрлэлт, 0.9 хувийг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 0.7 хувийг ашигт малтмалын олборлолт тус тус эзэлж байна.

Зураг 19. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, борлуулалт, 2018-2019 оны сар бүрээр, тэрбум төгрөг




Зураг 20. Үйлдвэрлэлт, 2017-2019 он, тэрбум төг




Зураг 21. Борлуулалт, 2017-2019 он, тэрбум төг



Хүснэгт 22. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, оны үнээр, сая төгрөг

| Салбар | Нийт бүтээгдэхүүн | | |
|---|---|---|---|
| | 2018 I-X | 2019 I-X | $\frac{2018}{2019}\%$ |
| Уул уурхай олборлох үйлдвэр | **14484.5** | **17776.0** | **122.7** |
| Төмрийн хүдэр олборлолт | 13421.3 | 16033.5 | 119.5 |
| Бусад ашигт малтмал олборлолт | 1063.2 | 1742.5 | 163.9 |
| Боловсруулах үйлдвэр | **814192.5** | **924953.7** | **113.6** |
| Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 311184.6 | 289580.3 | 93.1 |
| Мах, загас, ногоо, тос боловсруулалт | 2931.7 | 4575.0 | 156.1 |
| Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 36578.6 | 38836.1 | 106.2 |
| Хүнсний бусад бүтээгдэхүүн | 30979 | 35276.7 | 113.9 |
| Ундаа үйлдвэрлэл | 240695.3 | 210892.6 | 87.6 |
| Нэхмэлийн үйлдвэрлэлт | 369672.2 | 466069.6 | 126.1 |
| Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт | 3297.7 | 2683.3 | 81.4 |
| Арьс шир боловсруулах үйлдвэр | 11842.3 | 11521.5 | 97.3 |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл | 8648.3 | 3818.4 | 44.2 |
| Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 7150.7 | 10114.2 | 141.4 |
| Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа | 7816.7 | 7338.9 | 93.9 |
| Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 72131.5 | 77350.9 | 107.2 |
| Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн | 9470.2 | 11123.0 | 117.5 |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл | 10457.9 | 13333.6 | 127.5 |
| Төмрийн үйлдвэрлэл | 0 | 30450.0 | 0 |
| Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл | 264.5 | 309.0 | 116.8 |
| Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл | 882 | 600.0 | 68.0 |
| Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл | 1115.4 | 368.0 | 33.0 |
| Мебель тавилга үйлдвэрлэл | 258.5 | 292.9 | 113.3 |
| Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт | 88600.3 | 89518.0 | 101.0 |
| ДҮН | **917277.3** | **1032247.7** | **112.5** |

Хүснэгт 23. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, оны үнээр, сая төгрөг

| Салбар | Аж үйлдвэрийн борлуулалт | | | |
|---|---|---|---|---|
| | 2018 I-X | 2019 I-X | $\frac{2018}{2019}\%$ | үүнээс: экспорт, % |
| Уул уурхай олборлох үйлдвэр | **14484.5** | **17655.7** | **121.9** | **0.2** |
| Төмрийн хүдэр олборлолт | 13421.3 | 16033.5 | 119.5 | - |
| Бусад ашигт малтмал олборлолт | 1063.2 | 1622.2 | 152.6 | 100.0 |
| Боловсруулах үйлдвэр | **752459.7** | **977595.0** | **129.9** | **25.0** |
| Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 323928.4 | 409363.9 | 126.4 | 50.8 |
| Мах, загас, ногоо, тос боловсруулалт | 4132.2 | 4116.6 | 99.6 | 0.0 |
| Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 51158.2 | 59247.4 | 115.8 | |
| Хүнсний бусад бүтээгдэхүүн | 29908.8 | 36477.1 | 122.0 | |
| Ундаа үйлдвэрлэл | 238729.2 | 309522.8 | 129.7 | 0.30 |
| Нэхмэлийн үйлдвэрлэлт | 292633.8 | 398806.9 | 136.3 | 59.8 |
| Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт | 4196.8 | 3844.0 | 91.6 | |
| Арьс шир боловсруулах үйлдвэр | 11959.7 | 10170.8 | 85.0 | 24.8 |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл | 8420.4 | 3781.4 | 44.9 | |
| Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 7150.7 | 10114.2 | 141.4 | |
| Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа | 7633.9 | 6578.6 | 86.2 | |
| Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 74894.9 | 82026.1 | 17.3 | |
| Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн | 9798.5 | 11673.3 | 119.1 | |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл | 9303.2 | 12942.6 | 139.1 | |
| Төмрийн үйлдвэрлэл | | 27034.1 | | |
| Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл | 272.1 | 309.0 | 113.6 | |
| Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл | 882 | 60.0 | 6.8 | |
| Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл | 1126.8 | 597.2 | 53.0 | |
| Мебель тавилга үйлдвэрлэл | 258.5 | 292.9 | 113.3 | |
| Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт | 88600.3 | 89518.0 | 101.0 | |
| ДҮН | **855544.5** | **1084768.7** | **126.8** | |



## БАРИЛГА

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 2019 оны хоёрдугаар улирлын урьдчилсан гүйцэтгэлээр нийт 349.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий 200 барилга, байгууламж объектууд баригдаж байна. Эдгээр барилга байгууламжийн 61.1 тэрбум төгрөгийн (17.5%) өртөг бүхий барилга нь төрийн болон орон нутгийн өмчийн, 288.8 тэрбум төгрөгийн (82.5%) өртөг бүхий барилга нь иргэний болон хувийн хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна. Мөн баригдаж буй обьектуудыг давхарын хувьд бүлэглэн авч үзвэл 1-5 давхар (35.5%), 6-10 давхар (15.5%),11-ээс дээш давхар (41.5%) эзэлж байна.

Нийт гүйцэтгэлийн (99.8%) шинэ барилга, өргөтгөлийн ажил, (0.2%) их засварын ажил эзэлж байна. Шинэ барилга, өргөтгөл шинэчлэлийн ажлын гүйцэтгэлийн (72.3%) орон сууцны барилга байгууламжийн ажил эзэлж байна.



## МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО

Мэдээлэл, телевизийн нэвтрүүлэг дамжуулахын орлого 2019 оны 3 дугаар улиралд 1399.5 сая төгрөг болж, хүн амаас 9.2 сая төгрөг орсон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мэдээлэл, телевизийн нэвтрүүлэг дамжуулахын орлого 4548.5 сая төгрөгөөр (76.5%) буурчээ.

Хүснэгт 24. Мэдээлэл, холбооны салбарын үндсэн үзүүлэлт, III улиралд

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2018 | 2019 |
|---|---|---|---|
| Нийт орлого | мян.төг | 5948069.8 | 1399482.2 |
| Үүнээс: Хүн амаас орсон орлого | мян.төг | 9000 | 9200 |
| Байгууллагын компъютерийн тоо | тоо | 141 | 141 |

# ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2019 оны эхний 10 сард Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт иргэдээс 1470 өргөдөл, гомдол ирснээс 1411 нь хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэгдсэн байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй 33, хугацаа хэтэрсэн 26 өргөдөл байна.

Хүснэгт 25. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

| Байгууллагын нэр | Өргөдөл гомдлын тоо | Хэлбэр | | | | Агуулга | | | | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хуулийн хугацаанд хариу өгсөн | Хүлээгдэж байгаа | Хугацаа болоогүй | Хугацаа хэтэрсэн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Амаар | Бичгээр | Утсаар | Цахим сүлжээгээр | Гомдол | Санал | Мэдэгдэл | Хүсэлт | | | | | |
| Удирдлага | **4** | - | 3 | - | 1 | - | - | - | 4 | - | 4 | - | - | - |
| ТЗУХ | **81** | - | 66 | 6 | 9 | 19 | - | - | 62 | - | 78 | | 2 | 1 |
| СТСХ | **-** | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| ЭЗТХ | **30** | - | 9 | 5 | 16 | 4 | 8 | - | 18 | - | 29 | - | | 1 |
| НБХ | **50** | - | 34 | 5 | 11 | 6 | 1 | - | 43 | - | 50 | - | - | - |
| ТНААХ | **270** | - | 58 | 126 | 86 | 133 | 7 | 1 | 129 | - | 255 | | 13 | 2 |
| ХХҮХ | **58** | - | 45 | 6 | 7 | 18 | 1 | - | 39 | - | 57 | - | 1 | - |
| ХЗАТ | **40** | - | 32 | 3 | 5 | 14 | - | 2 | 24 | - | 40 | - | - | - |
| Цэргийн штаб | **132** | - | 132 | - | - | - | - | - | 132 | - | 132 | - | - | - |
| Аж ахуйн тасаг | **2** | - | 2 | - | - | - | 2 | - | - | - | 2 | - | - | - |
| **ЗДТГ-ын дүн** | **667** | **0** | **381** | **151** | **135** | **194** | **19** | **3** | **451** | **0** | **647** | **0** | **16** | **4** |
| ХөХҮХ | **89** | - | 52 | 20 | 17 | 30 | - | - | 59 | - | 89 | - | - | - |
| Газрын алба | **419** | - | 315 | 60 | 44 | 95 | 3 | - | 321 | - | 393 | - | 14 | 12 |
| Боловсролын хэлтэс | **102** | - | 34 | 50 | 18 | 49 | - | - | 53 | - | 95 | - | 1 | 6 |
| ОБХ | **5** | - | - | 1 | 4 | 1 | - | - | 4 | - | 3 | - | - | 2 |
| Албан бус-НТБ төв | **148** | - | 148 | - | - | - | - | - | 148 | - | 148 | - | - | - |
| Бүртгэлийн хэлтэс | **40** | - | 33 | 3 | 4 | 7 | - | - | 33 | - | 36 | - | 2 | 2 |
| **Дэргэдэх хэлтэс, албадын дүн** | **803** | **0** | **582** | **134** | **87** | **182** | **3** | **0** | **618** | **0** | **764** | **0** | **17** | **22** |
| **Нийт дүн** | **1470** | **0** | **963** | **285** | **222** | **376** | **22** | **3** | **1069** | **0** | **1411** | **0** | **33** | **26** |

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Танилцуулгыг эрхлэн гаргасан: Мэргэжилтэн Д.Оюунгэрэл


ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
Статистик
Мэдээ, мэдээлэл
Номын сан
Мэдлэгээ шалгах тоглоом
Валютын ханш
1212
1212.mn аппликейшнаас
СТАТИСТИКИЙН
мэдээллээ аваарай
СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН


2018 WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН
Статистик
Мэдээ, мэдээлэл
Номын сан
Мэдлэгээ шалгах тоглоом
Валютын ханш
1212
аппликейшнаас
СТАТИСТИКИЙН
мэдээллээ аваарай


Data lab
тооллого судалгааны микро мэдээллийн сан
SOCIAL NETWORK
www.facebook.com/StatisticMongolia/
www.twitter.com/statistic_mn
ЛАВЛАХ УТАС
1900-1212
ЦАХИМ ШУУДАН
information@nso.mn

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

## 2019 оны эхний X сар







| Үзүүлэлт | 2018 I-X | 2019 I-X |
| --- | --- | --- |
| Амаржсан эхийн тоо | 3 939 | 3 744 |
| Төрсөн хүүхдийн тоо | 3 863 | 3 780 |
| Халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо | 1 700 | 1 904 |

**Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо**

| | 2018 X | 2019 X |
| --- | --- | --- |
| Нийт | 758 | 655 |
| Эмэгтэй | 398 | 335 |






**Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо**

| 2018 I-X | 2019 I-X |
| --- | --- |
| 1 915 | 1 839 |

Дэлгэрэнгүйг http://www.ubstat.mn/Report хуудаснаас авна уу.





**Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, тэрбум төг**

| 2018 I-X | 2019 I-X |
|---|---|
| 917.3 | 1 032.2 |

**Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, тэрбум төг**

| 2018 I-X | 2019 I-X |
|---|---|
| 855.5 | 1 084.8 |



**Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт, хувь**

| 2018 X | 2019 X |
|---|---|
| 1.2 | 0.4 |






**Валютын зах зээлийн ханш**



1US$ = ₮

| 2018 X | 2019 X |
|---|---|
| 2 564.5 | 2 697.8 |



**Дүүргийн төсвийн орлого, сая төг**

| 2018 I-X | 2019 I-X |
|---|---|
| 62 500.6 | 70 553.3 |




**Дүүргийн төсвийн зарлага, сая төг**

| 2018 I-X | 2019 I-X |
|---|---|
| 51 134.2 | 61 235.7 |

Дэлгэрэнгүйг http://www.ubstat.mn/Report хуудаснаас авна уу.